



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/111/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.24 № 16/109

танай _____ -ны № _____ -т

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН
ХОШУУЧ Ж.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1.5	0.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	122.8	148.6
	Нийт хөрөнгийн дүн	124.3	148.7
	Нийт өр төлбөрийн дүн	0.1	0.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	124.2	147.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	124.3	148.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	250.2	286.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	241.8	263.1
	Үйл ажиллагааны үр дүн	8.3	23.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	8.3	23.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	235.0	250.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	235.0	250.6
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51.5	124.3
	Тайлант оны үр дүн	9.9	23.5
	Эцсийн үлдэгдэл	124.3	147.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	216.9	228.1
	Урсгал зардал	216.9	228.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	216.9	230.2
	Улсын төсвөөс санхүүжих	208.1	224.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	8.8	5.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Албан хаагч, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулах;

- Батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулж, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн, аймаг орон нутгийн төр захиргааны болон хууль хяналтын байгууллагуудтай нягт үр дүнтэй хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг туслалцаа авах талаар тодорхой ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллах;

- Тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллах тал дээр онцгой анхаарч ажиллах.

Шүүхийн шинжилгээний тухай хуульд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 46.8 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 46.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 3 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, үндсэн үйл ажиллагааны орлого, тээврийн хэрэгслийн татвар 0.1 сая төгрөг, хог хаягдал зайлуулах, бага үнэтэй түргэн элэгдэхийн зардал 0.1 сая төгрөгөөр төсвийн хэлбэлзлийн тайлангаас зөрүүтэй тайлагнасныг залруулав.

2. Завсрын аудитаар 2021.09.30-ны санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгөд 7.9 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсоныг залруулав.

3. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 36.0 сая төгрөгийг хувьцааны ногдол ашиг дансанд бүртгэснийг залруулав.

Зөвлөмж

1. Тодруулгатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Завсрын аудитаар 2021 оны 7, 8, 9 саруудын 37 ширхэг шаардах хуудас даргын зөвшөөрөл гарын үсэг зураагүй байхад зарлагадсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7 “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

2. Тодруулгатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 дансны 49 ширхэг 51.4 сая төгрөгийн бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шийдвэрлээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 31.3.3 “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

3. Тодруулгатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүйд 2.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөг хасах тэмдэгтэй илэрхийлэгдсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Энэ нь УСНББОУС 17-д “хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр элэгдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Бүртгэлтэй үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв бодуулах.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Шүүхийн шинжилгээний алба	6	46.8	3	46.8	-	-	-	-	3	-
	НИЙТ	6	46.8	3	46.8	-	-	-	-	3	-